

**МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХАМТ ӨРГӨН
МЭДҮҮЛСЭН ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛҮҮДИЙН ТАЛААРХ
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал

**НЭГ.НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

1.Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх.

“1 дүгээр зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай 17¹ дүгээр зүйл нэмсүгэй:

17¹ дүгээр зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт

17¹.1.Энэ хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1.а дахь дэд заалтыг 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал дагаж мөрдөнө.

17¹.2.Энэ хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1.б дэх дэд заалтыг 2027 оны төсвийн жилээс эхлэн дагаж мөрдөнө.”

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д. Үүрийнтуяа, М.Бадамсүрэн,
Ц.Баатархүү, Ж.Баясгалан, Б.Бейсен, Г.Лувсанжамц, З.Мэндсайхан,
Д.Пүрэвдаваа, Д.Энхтүвшин /цаашид “Ажлын хэсэг” гэх/**

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 15.2.1.а дахь дэд заалтын “2026 оны татварын жилд” гэснийг, 15.2.1.б дэх дэд заалтын “2027 оны татварын жилээс эхлэн” гэснийг “албан татвар төлөгчийн албан татвар суутган төлөгчтэй хийсэн” гэж, “1 дүгээр зүйл” гэснийг “2 дугаар зүйл” гэж, “2 дугаар зүйл” гэснийг “3 дугаар зүйл” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан: Ажлын хэсэг

3.Төслийн 2 дугаар зүйлийн “01 дүгээр” гэснийг “10 дугаар” гэж өөрчлөх.

Санал гаргасан: Ажлын хэсэг

4.Саналын томьёололын 1 дэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэрийн “ӨӨРЧЛӨЛТ” гэсний өмнө “НЭМЭЛТ,” гэж нэмэх.

Санал гаргасан: Ажлын хэсэг

**ХОЁР.ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Найруулгын санал:

1.Төслийн 4 дүгээр зүйлийн “8.1.3 дахь заалтын “төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, Засгийн газраар хэлэлцүүлэх зөвшөөрлийг авах” гэснийг “төрийн захиргааны төв байгууллагын санал, дүгнэлтийг авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлэх” гэж, мөн зүйлийн” гэснийг хасах.

Санал гаргасан: Ажлын хэсэг

**ГУРАВ.“ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН
ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

1.Төслийн 1 дэх заалтын “Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах” гэснийг “Монгол Улсын Үндсэн хуульд заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх, түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдох зарчмын” гэж өөрчлөх.

Санал гаргасан: Ажлын хэсэг

2.Төслийн 2 дахь дэд заалтыг хасах.

Санал гаргасан: Ажлын хэсэг

3.Төслийн 3 дахь дэд заалтыг доор дурдснаар өөрчлөн найруулах:

3/Энэ тогтоолын 1 дэх дэд заалтыг хэрэгжүүлэхдээ хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах, бүтээгдэхүүн арилжаалах зэрэг бүхий л үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу ил тод нээлттэй, үр ашигтай зохион байгуулах;

Санал гаргасан: Ажлын хэсэг

---oOo---

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал

**НЭГ.ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 18.4 дэх хэсгийн “хийж болно.” гэснийг “хийнэ.” гэж өөрчлөх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг хасах.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин

3.Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалтыг хасах.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг

4.Төслийн 3 дугаар зүйлийн 8 дахь заалтын 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.1.7 дахь заалт нэмэх:

“25.1.7.нийгмийн нөлөөллийн шинжилгээний санал, дүгнэлт;”

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат

5.Төслийн 5 дугаар зүйлийн “заалт, 17 дугаар зүйлийн 17.1.2.6 дэх дэд заалт, 18 дугаар зүйлийн 18.2.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.4.2 дахь” гэснийг хасах.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин

ХОЁР.ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС ГАРГАХ ЭРХ ОЛГОХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

1.Төслийн 1 дэх заалтын “12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.3-т” гэснийг “12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.3, 12.1.5-д” гэж, мөн заалтын “мөн зүйлийн 12.1.4-т” гэснийг “мөн зүйлийн 12.1.4, 12.1.5-д” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг

ГУРАВ.ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

1.Төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 5 дахь дэд заалт нэмэх:

“5/Тавантолгойн бүлэг ордтой холбоотойгоор байгуулсан, хэрэгжүүлсэн төрийн нууцад авсан гэрээ, хэлцэл, тэдгээрийг байгуулахыг зөвшөөрсөн, дэмжсэн төрийн нууцад авсан холбогдох бүх шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу төрийн нууцаас гаргах арга хэмжээг 2026 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор авч хэрэгжүүлж, Монгол Улсын Их Хуралд тайлагнах.”

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг